

## ИСЛАМЫН ШАШНЫ ФИЛОСОФИ ДАХЬ ТАНИН МЭДЭХҮЙ, МЭДЛЭГИЙН ТУХАЙД

**Түлхүүр үг:** исламын шашин, исламын шашны философи, жабарит чиглэлийн сэтгэгчид, казарит чиглэлийн сэтгэгчид, ашарийн үзэл.

Манай оронд сүүлийн арав гаруй жилд өрнө ба дорнын философийн түүх, орчин үеийн асуудлыг судалж боловсруулах ажил идэвхжиж түүний үр дүнд олон тооны сонирхолтой ном зохиол, эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлэгдэн гарчээ. Энэ бол ололт, ахиц юм. Гэтэл судалгаа боловсруулалтын ийм ололттой суурь дэвсгэр дээр ор нь үгүйлэгдэж, одоо хүртэл хөндөгдөхгүй байгаа нэг судлагдахуун бол исламын буюу мусульманы шашны болон шашны бус иргэний философи, тэдгээрийн түүх, орчин үеийн асуултууд мөн болно. Дэлхийн олон оронд энэ асуудлыг тал бүрээс нь судлаж, чухал үр дүн, ололтонд хүрчээ.

Манай оронд зөвхөн мусульманы философи төдийгүй ер нь ислам судлал, араб судлалыг үүсгэж хөгжүүлэх, үүний тулд юуны өмнө МУИС-ийн холбогдох сургуульд араб хэлний анги нээж мэргэжилтэн судлаачдыг бэлтгэх, энэ чиглэлээр арабын гол орнуудтай холбоо тогтоож хамтран ажиллах шаардлага тулгамдан тавигдаж байгааг бид ухаарч, хэрэгжүүлж эхлэх хэрэгтэй байна.

Бид энэхүү өгүүлэлд дундад зууны үеийн (VII-IX) исламын шашны философи дахь танин мэдэхүй, мэдлэгийн асуултын зарим талыг хөндөн авч үзэх зорилт тавьж байгаа болно.

Philosophy of religion (философия религии), religious philosophy (религиозная философия) гэсэн хоёр өөр ойлголт бүхий нэр томъёог монголосор шашны философи гэсэн нэг нэр томъёогоор буулгаж илэрхийлдэг. Энэ нь заримдаа хоёрдмол ойлголт төрүүлдэг бөгөөд тухайн тохиолдолд тэдгээрийн чухам альны талаар өгүүлж байгааг тухайн контекстээс үзэж

мэдэхээс өөр аргагүй болдог. Бид энд асуултыг islamic religious philosophy (исламская религиозная философия) гэсэн утгаар авч үзэх болно.

Philosophy of religion нь шашин судлалын нэн чухал, гол бүрдэл хэсэг бөгөөд утга агуулга, зорилгоороо шашны уг шинж, мөн чанар, эх сурвалж, үндсийг онолын түвшинд, философийн үүднээс судлаж нэгтгэн дүгнэсэн ерөнхий, цогцолбор ойлголтыг өгдөг хэсэг нь юм. Харин religious philosophy нь (шашинжсан, шашинлаг философи гэж тайлбарлаж болохоор юм) нэг талаар шашны догм сургаал, ертөнцийг үзэх үзлийг философийн үүднээс, философийн үндсэн ойлголт, нэр томъёог ашиглаж үндэслэж тайлбарладаг, нөгөөтэйгүүр философийн гол, чухал асуудлуудыг шашны догм сургаал, номлолын дагуу авч үзэж тайлбарладагаараа онцлогтой юм. Шашин бол зөвхөн сүсэг бишрэл, ишгэл үнэмшил төдийгүй хүн төрөлөхтөний соёл, оюун санааны амьдралын өсөлт хөгжлийн чухал үзэгдэл байдаг.

Бурхны ба христос шашин тэдгээрийг шүтдэг ард түмнүүдийн соёл, оюун санааны амьдралд дэвшилттэй, томоохон үүрэг гүйцэтгэсэнтэй нэгэн адил ислам шашин дэлхийн мусульманчуудын оюуны соёл, тухайлбал тэдний бичиг үсэг, хэл, утга зохиол, ном хэвлэл, сургууль, танин мэдэхүй, шинжлэх ухааны салбар чиглэлүүдийн үүсэл хөгжилд асар их ач тус өгчээ. Католик сүм хийд дундад зуунд байгаль шинжлэл, шашнаас ангид шинжлэх ухааны судалгааг хатуу хянаж, чөлөөтэй бодож сэтгэсэн, нээлт хийсэн эрдэмтдийг мөрдөн мөшгиж, шашины хуулиар шүүж, заримыг нь шатааж байсан билээ. Ислам шашин түүхэндээ харин ч үүний эсрэгээр шинжлэх ухааныг, ялангуяа байгаль шинжлэлийн хөгжил, нээлтүүдийг талархаж, эрдэмтэдийг дэмжиж, ивээж ирсэн байна. Үүний үр дүнд дундад зуунд ислам шашинтай орнуудаас, ялангуяа араб, Дундад азийн орнуудаас одон орон судлаач аль-Баттани, математикч аль-Хорезми, физикч, оптик судлаач Ибн аль-Хайсам, химич Жабир ибн Хайян, газар зүйч аль-Бируни, олон талын эрдэм мэдлэгтэй сэтгэгч аль-Кинди, Аль-Газали, нийгэм-улс төрийн сэтгэгч Ибн Халдун, шинжлэх ухааны олон салбарт нэвтэрхий эрдэмтэд аль-Фараби, Ибн-Сина ба бусад олон эрдэмтэн мэргэд төрөн гарч, холбогдох салбаруудын шинжлэх ухааны үндэс суурийг тавилцжээ.

Ислам шашин түүхэндээ танин мэдэхүй, эрдэм мэдлэг, боловсролыг эрхэмлэж байсны дагуу энэ шашны тогтолцоо, практикт шашны сургууль, шашны боловсрол чухал бөгөөд хүндтэй байр суурийг эзлэж иржээ. Энэ нь

ислам шашин ба түүний түүхтэй танил биш хүмүүст гайхшрал, эргэлзээ, үл итгэх байдал төрүүлж болох юм. Тиймээс ислам шашин эрдэм боловсрол, сургууль соёл, шинжлэх ухаанд яагаад тийнхүү талархаж хүндэтгэлтэй хандсан вэ? үүнд ямар учир шалтгаан байна вэ? гэсэн асуулт тавьж, түүнд түүхэн тодорхой жишээ баримтаар үнэн зөв, учирыг тайлсан хариу тайлбар өгөх хэрэгтэй болно.

Ислам шашин хүний оюун ухаан, амьдрал практикийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бодот агуулгатай мэдлэг, эрдэм боловсрол, тэдгээрийг бүрдүүлж бий болгодог бичиг үсэг, ном зохиол, сургуулийг эхнээсээ талархаж хандах болсон байна. Энэ нь ислам шашин үүсэж төлөвшсөн тухайн үеийн түүхэн нөхцөл байдал, оюун санааны амьдрал, тэр дотор исламыг үндэслэж үүсгэсэн Мухаммадын оюун санаа, шашны үйл ажиллгаатай нягт холбоотой байжээ. Бичиг үсэг, шашны ба иргэний философи, утга зохиол, шашны сургалт боловсролын олон зуун жилийн туршлага, уламжлалтай христос ба иудайн шашин дэлгэрч идээшсэн бүс нутгуудын уулзвар орчимд ислам шашин үүсэж, тэдгээрийн соёл, оюун санааны нөлөөг өөртөө тодорхой хэмжээгээр тусгаж шингээснийг бас анхаарч харгалзах хэрэгтэй. Мухаммад ба түүний хамтран зүтгэгчид, мусльманчууд нь христос, иудайн шашины эрдэм мэдлэгтэй лам хуврагууд, бичгийн хүмүүс, эдгээр шашиныг шүтэгчдийг "бичиг номын хүмүүс" (ахл аль-китаб) хэмээн нэрлэж хүндэтгэлтэй ханддаг байжээ. Эдгээр нь ислам шашны догм сургаал, тэдгээрийн үзэл санаа, үндэслэл, сэтгэлгээний түвшин нь тухайн цаг үеийн хэрэгцээ шаардлагын хэмжээнд хүрч боловсрогдоход ихээхэн нөлөөлсөн байна.

Мусульманы философи, түүний гол урсгал чиглэлүүд бүрэлдэж хөгжих үндсэн хоёр чухал эх сурвалж байсны нэгдэх нь ислам шашин, нөгөө нь эртний грекийн философи, ялангуяа Платон, Аристотелийн философи байлаа. Мусульманы философийн гол урсгал чиглэл, төлөөлөгчдийн үзэл сургаал дээрхи хоёр эх сурвалжийн нөлөөг өөртөө ямар нэг хэмжээгээр тусган илэрхийлжээ.

Эртний Грект үүсэж цэцэглэн хөгжсөн философи сэтгэлгээний улбаа мөр Византи гүрний нөхцөлд V-VII зууны үед тасарчээ. Энэ үед Византид христос шашин бэхжин ноёрхож, өөртөө эсрэг чиглэгдсэн аливаа үзэл, философи сэтгэлгээг хавчин боож байв. Византийн эзэн хаан Зенон 489 онд Аристотелийн философийг уламжилсан сургуулийг, дараа нь эзэн хаан

Юстиниан 529 онд шинэ платонизмын философийн сургуулийг тус тус хаах зарлиг буулгасан нь эртний грекийн философийн албан ёсны эцэс төгсгөл болсон юм. Үүний улмаас Платон, Аристотель нарын философийн үзэл санааг баримтлагч сэтгэгчдийг хавчин хөөж, тэд арга буюу Иран, Арабын бусад орнуудад ирж суурьших, тэнд грекийн философийг сурталчилан дэлгэрүүлэх, холбогдох зохиол бүтээлүүдийг хадгалан хамгаалах болжээ. Арабын хаад ноёд тэднийг хавчин гадуурхсангүй, харин ч ивээл халамжиндаа авч тэдний гүн ухааны үзэл, эрдэм мэдлэгт нь хүндэтгэлтэй ханджээ. Энэ байдалд арабын орнуудад төр ба шашин нэг хүний гарт төвлөрсөн, арабын философи сэтгэлгээ шашнаас бүрэн тусгаарлаж салаагүй, шашин ба философийн хооронд тэмцэл зөрчил хурцдаагүй, төрийн тэргүүн нэгэн зэрэг шашин сүм хийдийн тэргүүн болохын хувьд шашин ба түүний хүрээн дэх философийн үзэл сургаалд хүндэтгэлтэй, хүлээцтэй хандах шаардлагатай байсан явдал арабын орнуудад философи хөгжих, арабууд грекийн философийг сэргээж хүлээж авах, уламжлахад эерэгээр нөлөөлжээ. Тухайн үед арабын нэгдсэн халифат улсын бүрэлдэхүүн, ноёрхолд байсан Иран, Иракт, тухайлбал Багдад хотод соёл, шинжлэх ухаан, философийн томоохон төв оршиж тэдгээрт эрдэмтэд, сэтгэгчид ажиллаж байлаа. Багдад хотын "Мэргэн ухааны ордонд" мэргэжлийн орчуулагчид ажиллаж эртний грекийн философичид, эрдэмтэдийн бүтээлийг сири, перс хэлэнд орчуулж байжээ. Тийнхүү арабууд эртний грекийн философи, шинжлэх ухааны эх зохиол, дурсгалт эх бичгүүдийг уг эхээр нь хадгалан үлдэж, араб, сири, перс хэлэнд орчуулж дэлгэрүүлснээр дэлхийн оюуны соёлын өв уламжлалын хадгалалтанд үнэлж барашгүй гавьяа байгуулжээ. Европынхон эртний грекийн соёл, шинжлэх ухаан, философийн дурсгалт бичиг, ном бүтээлийг чухамдаа араб хэлнээс латин хэлэнд орчуулснаар нь дамжуулж хожмын XII-XIII зууны үеэс танилцаж эзэмшсэн байна.

Энэ талаар Б.Рассел: "Мусульманы иргэншил нь өөрийн агуу их эрин үедээ урлагийн салбарт болон техникийн олон салбарт гайхамшигтай ололтуудад хүрсэн юм. Энэхүү иргэншилийн ач холбогдол нь дамжуулагчийн үүрэгтэй байсанд орших бөгөөд түүнийг яасан ч дутуу үнэлж болохгүй. Эртний грек, ромын иргэншил ба шинэ европын иргэншлийг хооронд нь балар харанхуйн зуунууд таслан хувааж байлаа. Мусульманчууд ба византичууд шинийг санаачлах оюуны хүч энергигүй байсан болхоор

иргэншлийн багаж хэрэгсэл болох боловсрол, ном судар ба эрдэм мэдлэгт цаг заваа зориулах явдлыг хадгалан үлджээ. Өрнө дахин бүдүүлэг байдлаас гарсан үед нь түүнд мусульманчууд гол төлөв XII зуунд, византичууд ихэнхдээ XIV зуунд урам өгч урагш түлхжээ" гэж бичсэн байдаг (18, 400).

Энэ бүхэн исламын шашны философи, нийгэм-улс төрийн сэтгэлгээ хөгжих, танин мэдэхүй, мэдлэгийн асуудал чухлаар тавигдахад багагүй нөлөөлжээ.

Ислам шашны оюун сэтгэлгээ, мэдлэг төсөөллийн түвшин, ерөнхий төлөв байдлыг дан ганц гадны нөхцөл, хүчин зүйлсийн нөлөөгөөр тайлбарлавал өрөөсгөл болно. Ислам шашин арабуудын өөрсдийнх нь оюун санааны амьдрал, сэтгэлгээ, мэдлэгийн өмнөх үеүдийнхээс ялгаатай шинэ шат, түвшинд үүсэж бүрэлдсэн байна. Ислам шашин арабын овог аймгуудын тус тусын олон янзын шашин шүтлэгийг халж тэдгээрийн оронд нийтлэг, нэгдмэл том шашин болж төлөвшин тогтохын тулд тэдгээр жижиг шүтлэгүүдийн баларлаг, явцуу үзэл санаа, домгийн гэнэн мэдлэг төсөөллийн оронд байгал ертөнц, нийгэм-түүх, хүний амьдралын үзэгдэл, үйл явцуудыг логик сэтгэлгээнд тулгуурласан үзэл санаа, реалист мэдлэгээр тайлбарлаж ойлгох зайлшгүй шаардлагатай тулгарчээ. Өөрөөр хэлбэл ислам шашин тухайн цаг үед хэдийгээр шашны агуулга, өнгө аястай ч бай шинэ, боловсронгуй оюун сэтгэлгээнд тулгуурлаж байж л арабуудын өмнөх үеийн олон жижиг шүтлэгүүдийг халж гарч ирэх, энэ үед нэгэнт хөгжиж боловсронгуй болж тогтсон христос ба иудайн шашинтай эн зэрэгцэж, тэдгээрээс өөрийгөө ялгаж бие даасан шинэ том шашин болж төлөвшиж бэхжих бололцоотой байв. Эдгээр нь ислам шашин анх үүсэж төлөвших үеэсээ эхэлж хүний оюун ухаан, эрдэм мэдлэг, сургалт боловсролыг хүндэтгэж эрхэмлэх нэг том үндэс шалтгаан болсон байна.

Ислам шашны энэхүү онцлог чанарыг нөхцөлдүүлж нөлөөлсөн өөр нэг чухал хүчин зүйл бол Мухаммадын зүгээс хүний оюун ухаан, сэтгэлгээ бодит байдал, амьдралаас ургаж гарсан мэдлэг төсөөлөл, үзэл санаа, бичиг номтой хүмүүсийн эрдэм чадалд талархаж, хүндэтгэлтэй ханддаг байсан онцгой чанар мөн байв. Мухаммад өөрөө бичиг үсэг мэддэггүй, боловсролгүй байсан боловч нийгэм ба хүний амьдралд эрдэм мэдлэг, боловсрол, оюуны өндөр чадвар нэн чухал байдгийг ухаарч ойлгосон, угийн ухаалаг, бодол сэтгэлгээ сайтай хүн байжээ. Мухаммад шинэ ислам шашныг үүсгэж үндэслэх,

мусульманчуудын шинэ нийгэм, төр улсыг үндэслэж байгуулах үйл хэргийнхээ явцад оюун ухаан, эрдэм мэдлэг, боловсрол, соёл хичнээн чухал, хэрэгцээ шаардлагатай болохыг улам бүр мэдэрч ухаарах болжээ. Шинээр үүсэн бий болж буй ислам шашны үзэл санаа, номлол сургаалыг боловсруулж томъёолох, бичиж тэмдэглэхэд Мухаммадад учирч тохиолдсон хамгийн эхний саад бэрхшээл, өөрт нь байсан дутагдал бол тэрээр бичиг үсэгт тайлагдаагүй байсан явдал байв. Мухаммадын намтар түүхээр бичигдэж, уламжлагдан ирсэн ном бүтээлүүдэд зааж тэмдэглэснээр сахиулсан тэнгэр Жебраилаар дамжиж Мухаммадад зөнч дохио болж буусан Коран судрын анхны аят буюу зүйл нь бичиг үсэг, эрдэм боловсрол, хүн мэдэхгүй зүйлийг мэдэж ухаардаг, чаддаг болох тухай зүйл байсан ажээ. „Унш! Бүтээсэн эзэн бурхныхаа нэрийн өмнөөс унш ! ... Унш! Тэрээр үзгээр [бичихийг] хүмүүнд зааж сургасан болой. Тэрээр хүмүүнд мэдэхгүй зүйлсийг нь мэдүүлж, зааж сургасан болой” гэсэн утгатай аят буюу зүйл Мухаммадад буухдаа тэрээр: „Би уншиж чаддаггүй юм” хэмээн их л гэмшингүй, сандрангуй байдлаар давтаж хэлсэн гэдэг.

Мухаммад ислам шашныг үүсгэж дэлгэрүүлэхдээ хүчирхийлэл, дайн, эдийн засгийн албадлагыг хэрэглэсний зэрэгцээ хүн ардын оюун ухаанд хандаж ислам шашин бол эрдэм мэдлэг, оюун ухааны гэрэл гэгээнд үндэслэсэн шашин, харин бусад жижиг шашин шүтлэг нь “баларлаг, оюун ухааны гэрэл гэгээ тусаагүй харанхуй” болохыг сурталчилж байсан тухай мэдээ бий.

Мухаммедад эрэгтэй, эмэгтэй мусульман хүн бүр эрдэм мэдлэг, боловсролыг эрхэмлэн дээдэлж, тэдгээрт зүтгэж тэмүүлэх, сурч эзэмших явдал тэдний нэн чухал үүрэг, зорилт мөн гэж зааж байсан тухай нэгэн хадис бичигт тэмдэглэжээ. Өөр нэгэн хадист : „Аллах бурханд итгэж шүтсэн хүн оюун ухаантай . Мэдлэг, эрдэм ухааныг эрж хайж, түүнд суралцахыг хичээх нь мусульманчуудын шашны ариун үүрэг мөн. Эрдэм мэдлэг нь Хятад орон шиг [алс хол, түүнд хүрэх нь асар их бэрхшээл саадтай байсан ч] түүнд хүрэх гэж зүтгэж тэмүүл, түүнийг эрж хай!” хэмээн Мухаммад зааж сургамжилсныг тэмдэглэж бичжээ. (20, 71).

Танин мэдэхүй, мэдлэгийг эрхэмлэж заасан Мухаммадын заалт, сургаал айлдал Коран судрын олон арван бүлэг, зүйлүүдэд тусаж тэмдэглэгдсэн байна. Илм буюу эрдэм мэдлэг, шинжлэх ухаан гэсэн утгатай

үг, ойлголт Коран сударт нийтдээ 750 гаруй удаа давтагдаж хэрэглэгдсэнийг эртэмтэд судлаж тогтоосон байна. Тэдгээрт эрдэм мэдлэгийн ач тус, үнэ цэнэ, эрдэм сурах арга зам, энэ явцад тохиолдох бэрхшээл, эрдэмтэй ба эрдэмгүйн ялгаа зэрэг олон зүйлийн талаар заажээ.

Исламын шашны онол, философи нь энэ шашин үүссэнээс нэлээд хожуу үед IX-XII зуунд бүрэлдэж цэгцэрсэн байна. Гэхдээ ислам шашны сургаал, нийгэмд гүйцэтгэх үүрэг, байр суурийн асуудалд бие даасан чөлөөт байр сууринаас тэдгээрийг зөвтгөж дэмжих, шүүмжилж няцаах, эсвэл эргэлзэх байдлаар хандаж өөрийн хариу тайлбарыг өгч санаа бодлуудыг дэвшүүлж тавьсан философи, шашны онолын эх үүсвэр эл шашинтай бараг зэрэгцэж VII-VIII зууны зааг дээр бүрэлджээ. Гэхдээ энэ үед ислам шашныг үзэж ойлгох, хандах албан ёсны болж хүлээн зөвшөөрөгдсөн онол, номлол бүрэн бий болоогүй байлаа. Энэ нь тухайн үед нийгмийн сэтгэлгээ харьцангуй чөлөөтэй байж ислам шашны сургаал, Коран судрын үзэл санаа, тодорхой заалтуудыг янз бүрээр үзэж тайлбарлах бололцоо олгожээ.

Ислам шашны философи сэтгэлгээнд, ялангуяа түүний эхэн үед мэдлэг, оюун ухааны асуудал чухлаар тавигджээ. Коран сударт байгалийн юмс үзэгдэл, хүний бие цогцос, эрүүл мэнд, ариун цэвэр, (гигиена) хоол хүнс, эдийн засаг, санхүү, мөнгө, зээл, гэрээ, өмч хөрөнгө, түүнийг өвлөх, улс төрийн харилцаа, дайн, зэвсэг хэрэгсэл, хууль, эрх зүй, гэрлэлт, гэр бүл, ёс суртахуун зэрэг олон үзэгдлийн тухай тодорхой мэдлэг, ойлголт тухайн үеийн оюун ухаан ба практик туршлагын түвшинд боловсрогдож гаргасан байна.

Исламын философи сэтгэлгээнд мэдлэг, эрдэм бол бурхнаас хүнд заяасан оюун ухааны үр дүн, бүтээгдэхүүн мөн бөгөөд хүн өөрийнхөө ухааныг энэ насандаа юу хийх, хэрхэн яаж аж төрөх, буян ба нүглийг ялган салгаж мэдэж ойлгоход зориулж ашиглах ёстой гэсэн үндэслэлийг тулгуур үзэл болгож баримталж байлаа. Тиймээс ч ислам шашны сэтгэгчдийн бурхны тухай номлол, зохиол бүтээлийн оршил, эхний хэсэг нь ихэнхдээ мэдлэг, оюун ухааны тухай бичигдсэн байдаг. Шашин – философийн бүхэл бүтэн судар номыг “ Эрдэм мэдлэгийн судар” хэмээн нэрлэсэн нь ч бий.

Исламын философи сэтгэлгээний түүхэнд оюун ухаан, мэдлэг, үнэн, түүнд хүрэх арга замын асуудалыг жабарит ба кадаритын

чиглэлийн сэтгэгчид анх удаа хөндөж авч үзсэн байна. Бурханд тэрслэж харшлаж буй бүх зүйл оюун ухаанд харшилна, хүн буян ба нүглийг оюун ухаанаараа танин мэдэж, тэдгээрийн тухай мэдлэгтэй болно гэж тэд үзжээ. Кадарийагийн үзлийнхэн мэдлэг, оюун ухааныг бодит үнэнд хүрэх хэрэгсэл болгож ашиглахаасаа илүү маргагч эсрэг талынхны алдаа бурууг илрүүлж шүүмжлэх, няцаах зорилгоор ашиглаж байжээ.

Ислам шашны доторхи бүлгүүд, шашны үзэл номлолын урсгалуудын хоорондын маргаан мэтгэлцээний явцад энэ шашны онол, философийн үндэслэл болох калам (илм ал - калам) үүсэн бүрэлдсэн байна. Калам бол исламын түүхэнд анх удаа шашны философийн хэлбэрээр гарч ирсэн чөлөөт сэтгэлгээ байлаа. Тэрээр ислам шашинд бие даасан байр сууринаас, оюун ухааны үүднээс хандсан юм. Каламыг баримтлагч мутакалимчууд "зөвхөн оюун ухааныг эрхэмлэж баримтал" гэсэн зарчмыг мөрдлөг болгож байв. Тэд ислам шашны сургаал, Коран судрыг юмс үзэгдлийг танин мэдэх, үнэнд хүрэх эх сурвалж, үнэний шалгуур хэмээн үзээгүй, харин асуудал дэвшүүлж тавих, түүнийг бясалгах эх сурвалж болгож ханджээ. Калам ислам шашны хэвшмэл номлол, уламжлалд шүүмжлэлтэйгээр хандсан байдаг. Мутакаллимчуудийн маргаан явуулах гол арга нь маргагч эсрэг талынхны санаа бодол, дүгнэлтээс өөртөө тааламжгүй, эсвэл утга, ач холбогдолгүй бодол санааг гарган тавьж няцаах явдал байв. Тэд үзэл санааг нотлож батлах, дүгнэлт хийх эх сурвалж бол шашны нэр хүнд, сургаал биш, харин шүүмжлэлт оюун ухаан гэж үзжээ. Каламд эртний грекийн философи, маргах ургагийн нөлөө уламжлагдан илэрч байлаа.

Каламын анхны бөгөөд гол урсгал чиглэл нь мутазилитын үзэл юм. Энэ чиглэлд Аристотель ба шинэ платонизмын үзэл санаа нөлөөлж тусгалаа олсон байна. Мутазилитчүүд шашны үзэл сургаалд итгэл, сүсэгээр биш харин шүүмжлэлт, чөлөөт сэтгэлгээгээр ханджээ. Мутазилитчүүд аливаа итгэл үнэмшил, дүгнэлт, үзэл санаа үнэн зөв эсэхэд юуны өмнө эргэлзэж, дахин шалгаж, нягтлаж хандах хэрэгтэй гэж үзэж байв.

Ислам шашны уламжлалт, ортодокс номлол болох суннагийн сургаал, тухайлбал ханбалитын чиглэл каламын философийн үзэл санааг шашны байр сууринаас сөрж, шүүмжилж байлаа. Шашны философийн

энэхүү чиглэл Коран ба Суннад тусгагдсан шашны үзэл санаа, мэдлэгт тууштай тулгуурлахыг өөрийнхөө гол зарчим болгож хатуу баримталж байв. Коран ба албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн хадис судрууд Аллах бурхны үнэн зөв үг сургаал, заалтыг агуулж байгаа учраас тэдгээрийн үзэл санаа, утгыг "яагаад?" гэсэн асуулт тавьж шүүн хэлэлцэх, чөлөөтэй шүүмжлэх, эргэлзэх, өөр байдлаар тайлбарлан ойлгож болохгүй, шууд хүлээн зөвшөөрч итгэж шүтэх ёстой. Энэ үзэл шашин, шашны хууль цааз, эрх зүйг шинэтгэхийг хатуу эсэргүүцэж байв. Ханбалит үзэл ислам шашны уламжлалт үзэл сургаалын хамгийн хуучинсаг, догматик чиглэл байлаа. Энэ үзэлийн нийгэм-улс төрийн бааз суурь, дэмжиж дагагчид нь арабын мусульманчуудын доод ба дунд давхраа байжээ. Ислам шашны онол – философийн чухал асуудлуудыг логик сэтгэхүйгээр чөлөөтэй тайлбарласан калам сургаалын мутазилит чиглэлийг мусульманчуудын боловсролтой, дээд давхраа хүлээн авч дэмжиж байсан бол шашны номлолыг хэнд ч ойлгомжтой, энгийн үзэл бодол, итгэл үнэмшилд үндэслүүлж сурталчилсан ханбалит үзлийнхнийг боловсрол, соёл, амьдралын түвшин догуур хэсгийнхэн илүү дэмжин дагаж байжээ. Ханбалит үзэл шашны зан үйл, мөргөлийн ёс жаягийг өөрчилж шинэтгэх, Мухаммадын хамтран зүтгэгчдийг муулж гутаах, Аллах бурхны оршихуй, шинж чанар, илрэлийн талаар хэлэлцэж маргах, Коран сударыг бичигдэж бүтээгдсэн гэж үзэх, калам сургаалын үзэл санаа, сэтгэн бодох, маргах аргыг хүлээн зөвшөөрөхийг хэрхэвч тэвчиж болохгүй гэж үзжээ. Калам үүсэж дэлгэрснээс болж мусульманы нийгэм дотроо задарч, талцаж тэмцэлдэх болсон гэж ханбалит үзэл хатуу шүүмжилж байлаа.

Ислам шашны сургаалийг философи, логик сэтгэхүйн үүднээс үндэслэхэд ихээхэн анхаарсан шашны сэтгэлгээний нэг чиглэл бол ашарийн үзэл юм.

Ашарийн үзэл нь шашны асуудлуудыг авч үзсэн арга хандлага, өгсөн хариу тайлбар, баримталсан үзэл санаагаараа калам сургаалын өвөрмөц үргэлжлэл, шинэ илрэл байлаа. Гэхдээ энэ үзэл ханбалит үзэлд буулт хийх үүднээс тэдгээр тэмцэлдэгч хоёр чиглэлийн аль альнаас онцлогтой үзэл санааг гаргаж тавьсан байна. Ашарийн үзлийн энэ байр суурь нь тэрээр өөрийгөө албан ёсоор мутазилит үзлийн

эсрэг байгаа гэж тунхаглах боловч хэрэг дээрээ түүний рационалист уламжлалыг нийгэм – улс төрийн төвөгтэй шинэ нөхцөлд өвөрмөц хэлбэрээр үргэлжлүүлж байснаар илэрч байгаа юм. Тухайлбал ашарийн үзэл ертөнцийг үзэх үзэлийн хувьд шашны уламжлал, нэр хүндээс оюун ухаан, чөлөөт сэтгэлгээг дээгүүр тавьж, шашны сургаалд үнэмшиж итгэхийн өмнө тэрээр үнэн зөв эсэхэд эргэлзэж, бодож сэтгэх хэрэгтэй гэж үзэж байв. Нөгөө талаас шашны сургаалыг оюун ухаан, чөлөөт сэтгэлгээгээр шууд, эрс тэс шүүмжлэх, өөр утга санаагаар тайлбарлах, шашны догматик, хуучинсаг үзэлтнүүдтэй ил тод халз тулж маргахаас зайлсхийж байлаа. Ашарийн үзэл Коран судар нь цаг хугацааны тодорхой үед бүтээгдсэн гэсэн санааг үгүйсгэж, түүний мөн чанар мөнх бөгөөд Аллах бурхантай холбоотой, гэхдээ Коран судар үг хэллэг, үсэг тэмдгийн хувьд, өөрөөр хэлбэл хэлбэрийн талаас тодорхой үед бүтээгдсэн, тиймээс түүний утга санааг тодорхой хэмжээгээр чөлөөтэй тайлбарлаж болно гэж зааж байв.

Ашарийн үзэл мэдлэг, оюун ухааны уг шинж, эх үүсвэрийн асуудлыг авч үзэх, тайлбарлаж ойлгох талаар ургашилсан алхмуудыг хийжээ. Энэ чиглэлийн гол төлөөлөгчдийн нэг Абу Бакир ал – Бакиллани (IX – X зуун) “ат – Тамхид” хэмээх судартаа оюун ухааны мэдлэг гэдэг бол бодит юмс ямар байгааг тэр байдлаар нь таньж мэдэхийг хэлнэ, мэдлэг нь бурхны мөнхийн мэдлэг ба танин мэдэх чадвар бүхий ухаант хүний түр зуурын мэдлэг гэсэн хоёр хэсэгт хуваагдана, сүүлчийнх нь зайлшгүй буюу интуитив, дискурсив буюу түрүүчийн бодомжинд тулгуурлаж үүссэн мэдлэгт хуваагдана, зайлшгүй мэдлэг нь эргэлзээгүй байдаг, гэхдээ оюун ухаан, сэтгэж танин мэдэхүй нь хэмжээ хязгаартай бөгөөд түүгээр бурханыг танин мэдэх аргагүй гэж заажээ.

Ашарийн чиглэлийнхний мэдлэг, танин мэдэхүйн тухай сургаалыг нэрт гүн ухаантан, шашны сэтгэгч ал – Газали (1058 - 1111) цаашид гүнзгийрүүлэн боловсруулж хөгжүүлсэн байна. Тэрээр “Шашин шүтлэгийн тухай шинжлэх ухааныг сэргээх нь” хэмээх бүтээлдээ оюун ухаан, мэдлэгийн талаархи үзэл баримтлалаа гаргаж тавьжээ. Түүний үзлээр оюун ухаан бол Аллах бурхнаас хүнд хүртээсэн хишиг, чадвар бөгөөд хүн түүгээр эрдэм мэдлэг эзэмшинэ. Мэдлэг нь зан байдлын мэдлэг, оюун ухааны ба бурхны гэгээрлийн мэдлэг гэсэн хоёр хэсэгт хуваагдана.

Хүн метафизикийн нарийн асуудал, бурхны оршихуй, шашны сургаал, дүгнэлтийн мөн чанар, утга санааг оюун ухаанаар танин мэдэж чадаггүй. Тиймээс бурхан, шашинд сэтгэлгээрээ итгэн үнэмшиж, сүсэглэн шүтэх ёстой. Итгэл үнэмшил, шүтлэг бишрэл нь хүний сэтгэл зүрхэнд угаасаа агуулагдсан байдаг. Оюун ухаан, мэдлэг нь бүхэлдээ шашны шинж агуулгатай гэж ал – Газали үзжээ.

Шашны сэтгэлгээний суфист чиглэл шашны үзэл сургаалыг оюун ухаан, мэдлэгээр үндэслэх, зөвтгөх, эсвэл шүүмжилж няцаах аргагүй гэж үзэж байв. Хүн ертөнцийн юмс үзэгдэл, бурхныг оюун ухаанаараа бие дааж танин мэдэж чадахгүй. Тэдгээрийг ухааран ойлгох арга зам бол бурхны үг, сургаал болох Коран сударт бууж бичигдсэн шашны мэдлэгийг итгэл сүсгээр шууд хүлээн зөвшөөрч үнэмших явдал юм. Хүний оюун ухааны ( ал – акл ) танин мэдэх чадвар , хүрээ хэмжээ нь угаасаа хязгаарлагдмал байдаг. Оюун ухаан, мэдлэг нь дангаараа хүний мэдрэх эрхтэнүүдийн ихээхэн хуурамч , өнгөцхөн, алдаа төөрөгдөлтэй мэдрэмж , сэрлийн үндсэн дээр бүрэлдэнэ. Энэ нь харанхуй байран дахь зааныг хүмүүс ямар зүйл болохыг нь танин мэдэх гэж оролдохдоо нэг нь түүний сүүлийг гараараа тэмтэрч үзээд энэ бол усны хоолой , нөгөө нь чихийг нь барьж үзээд энэ бол том хэмжээний сэрүүсэх дэвүүр, гурав дахь нь зааны хөлнүүдийг тэмтэрч энэ бол багана, дөрөв дөх нь зааны нурууг тэмтэрч энэ бол асар том хаан ширээ байна гэсэнтэй адил. Тэгэхлээр мэдрэмж , сэрлээс эх үндэстэй оюун ухаан , мэдлэг өөрөө бодитой , үнэн утга агуулгатай биш учраас түүгээр бодит байдлыг танин мэдэх аргагүй гэж суфизм үзжээ. Гэхдээ Суфизм хүний танин мэдэх чадвар , ер нь юмс үзэгдлийг танин мэдэж болохыг ор тас үгүйсгээгүй ажээ. Танин мэдэхүйн гол, чухал эрхтэн, хэрэгсэл бол зүрх сэтгэл мөн гэж суфизм үзжээ. Тухайлбал Ибн Араби “ Танин мэдэхүй гэдэг бол зүрхээрээ хүртэж танин барихуй мөн. Зүрх угаасаа цэвэр ариун , тод байдаг . Оюун ухаанаар танигдаагүй зүйл зүрхээр танигдана” гэжээ (17, 188-190 ) . Суфизм нөгөөтэйгүүр хүний танин мэдэхүйд гадны юмс үзэгдэл хуурамч, гаж нөлөө үзүүлдэг, харин хүний субъектив төсөөлөл , ургуулан бодохуй , оюун санааны мансуурал, хувийн туршлага чухал үүрэгтэй гэжээ.

Ислам шашны сэтгэгчдийн далдыг, ид шидийг шүтэгч зарим хэсэг нь хүмүүсийг оюун ухааны шилмэл хэсэг (элита) буюу гэгээнтэн, хутагт хувилгаад ба тэдний оюун ухааны гэрэл гэгээт замаар араас нь дагаж явах ердийн харц олон гэсэн хоёр хэсэгт хуваажээ. Энэ бол нийгмийн анги давхраа, улс төрийн удирдлага, засаглалын харилцааг хүмүүсийн оюун ухаан, мэдлэг, танин мэдэх чадварын ялгаагаар үндэслэж зөвтгөх оролдлогын илрэл байв. Гэхдээ суфизм жирийн харц олны дотор ч оюун ухааны гэрэл гэгээтэй, эрдэм мэдлэгтэй хүмүүс байдаг, ер нь хүмүүс бие дааж эрдэм мэдлэг эзэмших, түүгээр өөрийгөө төгөлдөржүүлж боловсруулахыг хичээх хэрэгтэй гэсэн санааг талархан дэмжиж байжээ.

Суфизмын философийн үзлийн хөгжил шашны нэрт сэтгэгч Мухи ад-Дин ибн аль Арабийн (1165-1240) бүтээл туурвилтай салшгүй холбоотой. Тэрээр суфизмын гурван зуугаад жилийн хөгжлийн үр дүнг нэг ёсондоо нэгтгэн дүгнэсэн юм. Ибн-Араби сэтгэлгээ, танин мэдэхүйд оюун ухаан, бясалгалаас зөн билгийн мэдлэг ( интуици ) давуу чанартай байдаг гэж үзжээ. Шүтлэгтний гол зорилго бол энэ насны хуурамч амьдралаас хөндийрч, сэтгэл зүрхээрээ бурхантай нийлж уусах явдал гэсэн байна. Ахуй, ертөнц нэгдмэл чанартай бөгөөд тэдгээр нь бурхны нэгдмэл чанарын илрэл юм.

XIII-XIV зуунд суфист философи ид цэцэглэн хөгжиж, харин үүнээс хойшхи үед хөгжин болосрогдох дотоод боломж, бүтээлч шинжээ алдаж, шашны болон шашны бус философийн янз бүрийн чиглэлүүдийн маргаан, тайлбарын бай болж хувирсан байна.

Дүгнэж хэлэхэд исламын шашны философи нэг талаас хүний оюун ухаан, мэдлэг, танин мэдэхүйг чухалчилж эрхэм үнэт зүйл болгож хандсан ба нөгөө талаас тэдгээр нь хүн бие дааж бодит байдлыг танин мэдэх, бодит үнэнд хүрэх хэрэгсэл биш, хүнд тийм чадвар, бололцоо хомс, оюун ухаан нь Аллах бурхны үнэн зөв үг сургаал болох Коран судрын үзэл санаа, үг өгүүлбэр, заалтыг мэдэж ойлгох, итгэж үнэмших, сүсэглэж дагах хүрээ хэмжээгээр хязгаарлагдана гэж үзээд оюун ухаан, түүний танин мэдэх чадвар, мэдлэгийг шашин шүтлэгт нийцүүлж захируулжээ. Исламын шашны философийн оюун ухаан, мэдлэг, танин мэдэхүйн талаархи сургаал нь эдгээр асуудал шүүмжлэлт, чөлөөт сэтгэлгээнд

тулгуурласан шашны бус философид чухлаар тавигдаж боловсрогдоход ихээхэн нөлөөлсөн байна.

### Резюме

Данная статья написана на основе доклада, сделанного на симпозиуме монгольских философов, который организован кафедрой философии МонГУ. Статья посвящена обзорному рассмотрению вопроса о познании, знании в основных направлениях религиозной философии ислама в период VII-IX веков.

В начале статьи автор подчеркивает необходимость зачинания в Монголии исламоведения в целом, изучения вопросов религиозной и светской философии ислама в частности.

С начала возникновения ислама на протяжении веков на мусульманском Востоке высокого развития достигли светские науки, в том числе светская философия ( фальсафа ), а также развивалась религиозная философия. В них актуальной ставилась проблема познания и знания. Этому способствовали такие обстоятельства и факторы, как влияние греческой философии на становление мусульманской философии, отсутствие узаконенной догматики в исламе, одобрителное отношение Мухаммада к знанию и другие.

Тексты Корана и сунны дают основание утверждать, что знание в исламе рассматривается в качестве одной из наиболее важных духовных ценностей. Согласно преданию, Мухаммад наставлял: " Поиск знания есть религиозный долг каждого мусульманина " или " Ищи знание, даже если оно [ так не далеко, как ] Китай, ибо поиск знания есть религиозный долг каждого мусульманина". "Невежеству", " незнанию " язычества Мухаммад противопоставил религию "знания " – ислам. Новую веру он внедрял не только с помощью военной силы и экономического принуждения, но и через обращение к разумению людей, стремясь убедить их в превосходстве ислама над другими учениями.

В статье отмечается, что первыми "задумавшими" и "пререкающимися" в среде мусульман были кадариты, споры которых с противниками-джабаритами, отрицавшими за человеком свободу выбора, положили начало рефлексии вокруг текстов Писания и предания.

Мутазилиты, религиозные философы, особенно большое внимание уделяли концепции знания, ибо они пытались всю божественную науку подвергнуть суду разума, построив здание веры на его фундаменте. Именно они широко ввели в обиход логические труды античных философов и утверждали логику, рациональное доказательство в качестве основного пути постижения истины.

Калам представляет собой первую философски выраженную форму свободомыслия в исламе. Они давали догматам ислама толкование, основанное на разуме, а не на слепом следовании религиозным авторитетам. Основная установка сторонников калама ( мутакаллимов ) выражена в тезисе " Следуй одному только разуму". Каламу были присущи ярко выраженный критический дух, рационализм и решительное отрицание догматического традиционализма.

Первым крупным явлением калама стала школа мутазилитов. Мутазилитское учение ориентировалось на традиции Аристотеля и неоплатоников. Рационализм мутазилитской доктрины выразился в утверждении приоритета разума над верой. Мутазилизм оставил неизгладимый след. Именно благодаря ему на смену примитивно-бездумному традиционализму ранних мусульманских богословов и эзегетов пришли ашариты.

Первое систематическое изложение ашаритской доктрины было дано Абу Бакром ал-Бакиллани, перу которого принадлежит трактат "ат-Тамхид", открывающийся обсуждением проблемы природы знания или " науки " – илм. Последняя определена автором как " знание предмета таким, каков он реально есть ". Знание разделяется на две категории: на вечное знание Бога и временное знание тварей ( люди, ангелы, джинны ), способных познавать. Ашариты вслед за мутазилитами признавали значение рационального знания, но в отличие от последних, строго ограничивали его пределы.

Мусульманская традиция теологической рациональности проявилась наиболее последовательно и ярко у ал – Газали. Он в своем трактате " Воскрешение наук о вере " говорит о существовании четырех определений " разум ". В целом ал – Газали предпринял попытку критики и в то же время некоторого " синтеза " всех известных его современникам подходов к познанию.

В статье в сжатом виде рассмотрен вопрос о познании и знании в суфизме. Суфии считают, что разум ( ал – акл ) играет позитивную роль лишь в ограниченной области познания. Заключение разума выводятся на основании показаний органов чувств, свидетельства которых чрезвычайно обманчивы. Сердце, а не разум, по убеждению суфиев, является главным органом познания.

В заключении статьи автор отмечает, что концепции основных направлений религиозной философии ислама о познании и знании способствовали актуальной постановке и обстоятельному рассмотрению данной проблемы в светской философии на мусульманском Востоке в средние века.

#### **Ашиглаж, иш татсан ном бүтээл**

1. Беляев Е.А. Арабы, ислам и арабский халифат в раннее средневековье. М., 1965
2. Большаков О.Г. История Халифата. 1. т. Ислам в Аравии(570-633). М., 1989
3. Васильев Л.С. История религий Востока. 3-е изд, перераб. и доп. М., 1998
4. Гибб. Арабская литература: Класический период. Перевод с англ. П.А. Грязневича. М., 1960
5. Григорян С.Н. Средневековая философия народов Ближнего и Среднего Востока. М., 1966
6. Ибн Хишам. Жизнеописание господина нашего Мухаммада, посланника Аллаха.- Хрестоматия по исламу. Пер. с арабского. вввод и примеч.- М., 1994. стр. 12-26.
7. *Избранные произведения мыслителей стран Ближнего и Среднего Востока IX-XIV вв. М., 1961*
8. Ислам в истории народов Востока. М., 1981
9. Ислам. Краткий справочник. М., 1983
10. Ислам. Энциклопедический словарь. М., 1991
11. Ислам: религия, общество, государство. М., 1984
12. История восточной философии. Учебное пособие. М., 1998
13. Кимелев Ю.А. Философия религии. Систематический очерк. М., 1998
14. Коран. Перевод с арабского И.Ю. Крачковского. М., 1990
15. Массэ А. Ислам: Очерк истории. М., 1961

16. *Основы религиоведения. Учебник. 2-е изд. М., 1998*
17. Роузентал Ф. Торжество знания: Концепция знания в средневековом исламе. Пер. с англ. С.А. Хомутова. М., 1978
18. Рассел Б. История западной философии. В 3 кн. 2-е изд. Новосибирск, 1997
19. Соколов В.В. Средневековая философия. Учеб. Пособ. М., 1978
20. Степанянц М.Т. Восточная философия: Вводный курс. Избранные тексты. М., 1997
21. Хадисы Пророка. Перевод с арабского и комментарии И.В. Пороховой. М., 2000
22. Фролова Е.А. Проблемы веры и знания в Арабской философии. М., 1983